



ДИСПЕТЧЕРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ
ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2016 оны 04 сарын 06 өдөр

Дугаар 52

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ, худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 47 дугаар зүйлийн 47.4, 47.6, Сангийн сайдын 2012 оны 301 дүгээр тушаалаар баталсан Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагааны урамшууллыг зохицуулах журмыг 3 дугаар зүйлийн 3.3-ыг үндэслэн ТУШААХ нь:

1. Тус компанид шуурхай үйлчилгээнд ашиглагдах автомашин нийлүүлэх компанийг сонгон шалгаруулах тендерийг үнэлэх Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Н.Бат-Өлзий ХМС-ийн программын инженер

Үнэлгээний хорооны гишүүн: Ч.Мөнх-Эрдэнэ Нийлмэл реле хамгаалалтын инжене

Нарийн бичгийн дарга: Х.Айтолхын Компьютерийн сүлжээний инженер

2. Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор мэргэжлийн холбоод хувийн хэвшлээс үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд оролцож байгаа төлөөллийн ажилласан цагийн хөлсийг Сангийн сайдын 2012 оны 301 дүгээр тушаалаар батлагдсан журмын дагуу тооцон олгохыг Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга /Баярцэнгэлд/-д зөвшөөрсүгэй.

3. Техникийн тодорхойлолт бэлтгэх, тендерийн баримт бичгийг боловсруулах, зарлах, тендерт оролцогчдын ирүүлсэн материалыг хүлээн авч, үнэлэлт дүгнэлт гаргуулахаар мэргэжлийн чиглэлийн хүмүүсийг татан оролцуулах, тендерийн үйл ажиллагааг ил тод, шударга, хуулийн дагуу явуулж тендер шалгаруулалтын үйл ажиллагааны тэмдэглэгээг товч, тодорхой тэмдэглэж, "ХАМГИЙН САЙН" үнэлэгдсэн тендерийг шалгаруулан эрх олгох тухай зөвлөмжийг танилцуулахыг Үнэлгээний хорооны дарга /Н.Бат-Өлзий/-д үүрэг болгосугай.

4. Тендерийн баримт бичгийг боловсруулах, оролцогчдын ирүүлсэн материалыг хүлээн авах, нээх, үнэлэх ажиллагаа явагдах үеэр Үнэлгээний хорооны гишүүдийг ажиллах боломжоор хангахыг холбогдох алба, хэлтсийн дарга нарт үүрэг болгосугай.

5. Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, хүний нөөцийн хэлтэс /С.Намчиндорж/-т үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Х.ЦОГТБААТАР